

ӨНДӨР ГЭГЭЭН ЗАНАБАЗАРЫН БАЙГУУЛСАН ХҮРЭЭ ХИЙДҮҮД БОЛОН НОМЫН ИХ ХҮРЭЭ

Ч.Банзрагч

Өгүүллийн товч утга: Өндөр гэгээн Занабазар Халхын анхны томоохон хүрээ хийдүүдийг үндэслэжээ. Эл өгүүлэлд Шанхын баруун хүрээ, Номын их хүрээ, Төвхөн хийд, Цахиуртайн хурал, Сайныг бадруулагч сүм, Зүүн хүрээг байгуулахад Өндөр гэгээн Занабазарын гүйцэтгэсэн үүргийг авч үзсэн болно.

Түлхүүр үг: Өндөр гэгээн, хүрээ, хийд, сүм, лам, хутагт

Монгол оронд 1921 оноос өмнө 700 гаруй сүм хийд, 100 мянга гаруй лам нар байсан тухай мэдээ байдаг. Үүнээс наян долоон хүрээ хийд нь Богд Жибзундамба хутагтыг шууд харъяанд байжээ. Эдгээрээс арван нэгэн хүрээ сүмийг тэргүүлэх байр суурьтай гэж үзэж байжээ. Үүнд: Шанхын баруун хүрээ, Хэрлэнгийн зүүн хүрээ, Номын их хүрээ, Төвхөн хийд Өршөөлийг соёогч сүм, Буянзалбирах сүм, Билиг өлзийт сүм, Амарбаясгалан, Дамбадаржаа зэргүүд байжээ. Өндөр гэгээн Занабазар зургаан хүрээ сүмийг гардан байгуулжээ. Үүнд:

1. 1647 онд байгуулагдсан Шанхын баруун хүрээ
2. Номын их хүрээ. "Рибогэжэйганданшадублин" 1654 онд байгуулагдсан.
3. Сайн ноён хан Намнансүрэнгийн хошууны нутаг Хутаг ууланд 1659 онд байгуулсан Төвхөн хийд.
4. Түшээт хан аймгийн Дайчин бэйл Мөнхочирын хошууны нутаг 1666 онд байгуулагдсан Цахиуртайн хурал.
5. Сайныг бадруулагч сүм. Энэ сүм Хараа, Ерөөгийн хавьд Түшээт хан аймгийн Баатар вангийн хошуунд байжээ.
6. Түшээт хан аймгийн Дархан чин ван Дондовдоржийн хошууны нутаг Тогоос Гүш уулын энгэр, Хэрлэн голын захад 1701 онд байгуулагдсан Зүүн хүрээ энэ зургаан болно.

Баруун хүрээ болбоос Эрдэнэ зуугийн ойр байгуулагдсан Өндөр Богдын 1651 онд долоон аймаг нэмж байгуулсан томхон хурал номын газар байжээ. Өндөр гэгээнтний айлдварт "Баруун хүрээ болбоос миний хүрээ хийдийн эн тэргүүний орон мөн. Бусад хүрээ хийдээс онц ялгавартай"¹ хэмээн сургажээ.

¹ Ч.Банзрагч, Б.Сайнхүү "Монголын хүрээ хийдийн түүх" УБ.2004.109 тал

Номын их хүрээ “Рибогэжэйганданшадублин” нь Туул голын эхэнд гурван их сарьдаг уулын дунд Төвдийн сүм хийдийн загвараар цогцлуулсан дөрвөн сүм, гурван суварга нийт долоон байгууламжтай шарын шашны сүм хийдийн томоохон цогцолбор байжээ. Энэ хүрээг 1654-1687 онд ихээхэн хүч хөрөнгө гаргаж 20 гаруй жилийн турш барьж гүйцээжээ. Энэ хүрээг Богдын Их хүрээ одоогийн Улаанбаатар хотын анхны эх үүсвэр гэж үздэг юм.

Төвхөн хийдийг “Өндөр гэгээнтний Хутаг ууланд заларч бясалгалыг таалсан учир тэрхүү газар байгуулж Махгал, Чойжил тэргүүтэн бурхадыг цүглэн тахиулан буй”² гэж Сайн ноён ханы сүм хийдийн түүхэнд бичжээ.

Цахиуртайн хурал бол авсаархан бага газар боловч Халх дахинд эзлэх байр суурь, нэр хүндээрээ өндөр үнэлэгддэг газрын нэг байжээ. Түшээт хан Гомбодоржийн хатан Ханджамцад аягачин болж явсан 2 хүүхэн байв. Тэр цагт Өндөр гэгээнтэн Түшээт ханы агь болон мэндлэхэд 2 хүүхний эгчээр эх бариулж аваад энхрийлэн өсгөв. Бага хүүхний 2 хөхнөөс шалтгаангүй байтал их сүү асгаран гарсныг Өндөр гэгээн шимэн зооглож бие лагшин торнин боловсроод их хүүхнийг Авай ижий, бага хүүхнийг Далай ижий хэмээн нэрийджээ.

Өндөр Богдын гэгээнтэн 32 сүүдэр зооглосон Энх-Амгалангийн тавдугаар (1666) онд өөрийн мутраар хар торгон дээр 9 зүйлийн эрдэнэсээр зурсан Балданлхам сахиус гайхамшигийн адистадтай нэгнийг хайрлав. Далай ижийд мөн тэр мэт бүтээсэн Махгал сахиус нэгийг хайрлав. Тэр цагаас эхлэн 2 аягачны садан төрөл хүмүүс, отог хамжлагын ардууд Гэгээнтний зөвшөөрснөөр 2 сахиусанд өргөө гэр байгуулан залж өдөр бүр жасаа хурал хурах болжээ. Халхчууд бүгдээр Манж чин улсын төрд дагаар орохын өмнө Өндөр гэгээнтэн Авай ижий, Далай ижий хоёрт хятад шунхан барын Ганжуур ном (108 боть) гүйцэд нэг нэгийг хайрласныг мөн хурлын газар залжээ. Хойно Үйзэн засаг Хаймчигийн үед тус хошууны аав ноён гэгчид Далай ижийг худ худгуй болгон өгч 2 тийш тасрахад Цахиурт хэмээх газар Бурахн шүтээн, ном судрыг залаад сан жас байгуулан хөгжөөсөн хэмээн Дайчин бэйс Батсуурийн хошууны хүрээ хийдийн түүхэнд дурьджээ³.

² Мөн зохиол 54-55 тал

³ МУТАрхив. ФМ-85, Д-2, ХН-838, Х-4

Сайныг бадруулагч сүм нь "Хүүхэн ноёны дөрвөн отгийн дунд харъяат ардууд эрт цагаас хадгалан тахисан Ширээ бурхан гэдгийг гол шүтээн болгосон сүм юм. Энэ бурханыг Өндөр Богд урласан хэмээх бөгөөд олон хүмүүнд мэргэнийг үзүүлж энэ хойтын зовлонгоос авран ивээх нь гайхамшигтай хэмээдэг бөлгөө. Энэ сүмийн шүтээнийг хойт зүгийн олон шавь нар бүгдээрээ сүслэн биширсэн нь учир ялгавартай болой"⁴ гэж архивын баримтад дурьджээ.

Өндөр Богдын гэгээнтэн Энх-Амгалангийн дөчдүгээр (1701) онд төмөр туулай жил Засаг төрийн жүн ван Дондовдоржийн хошууны нутаг Тогос Гүш уулын энгэрт Цогчин, Цаннид, Жүд, Манба, Зурхай, Бадам-Ёго, Ламрин, Майдар зэрэг олон дацан сургууль бүхий хурал номын газар үүсгэж Дээдийн түмэн өлзий бататгах болон хамаг амьтны тусын тулд ном уншуулсан түүхтэй.

Өндөр гэгээн Занабазарын цогцлуулсан хүрээ хийдүүдийн дотроос охь манлай нь болсон Номын их хүрээний тухай дэлгэрүүлж онцлон тэмдэглэхийг хүсэж байна.

1873 оны арван хоёрдугаар сарын тавны өдөр бичигдсэн Архивийн баримтад "Их хүрээ болон түүний дацан сургуулиудын үүсэл гарлын тухай" тодорхой дурьджээ. Энэ баримтад "II Богд гэгээнтний үед шороон хонин жил (1739он) Жүд дацан байгуулсан. Одоо 134 жил болсон. Модон үхэр жил (1745 он) Бадам-ёго дацан байгуулав. Одоо 128 жил болсон. Гал хулгана жил (1756 он) Гомон дацангийн судрын ёсоор Дашчоймбол дацан байгуулсан. Одоо 113 жил болсон. IV Богд гэгээнтний үед Шорон тахиа жил (1789 он) Зурхай дацан байгуулсан. Одоо 84 жил болсон. Гал барс жил (1806 он) Дүйнхорын хурал байгуулсан. Шороон могой жил (1809 он) Гунгаачойлин дацан байгуулсан. Одоо 64 жил болсон. Модон морин жил (1834 он) Их хүрээнд Майдар бурхан бүтээж сүм байгуулсан. Одоо 39 жил болсон. Шороон нохой жил (1838 он) Гандантэгчинлэн хүрээ байгуулсан. Одоо 35 жил болсон"⁵ гэх мэтээр дурьджээ.

Ийнхүү Өндөр гэгээнтний үүсгэсэн Номын Их Хүрээ нь дараа дараагийн Богд хутагтуудын үед өргөжин тэлж өрнөн дэлгэрсээр иржээ. Өндөр Богдын гэгээн 1886 онд Соёмбо үсгийг зохиож бусад олон бичиг үсгийг судлан сурч шавь лам нарын дунд дэлгэрүүлжээ. Өндөр гэгээнтний дараа дараагийн залгамж хутагтууд Их хүрээний

⁴ МУТАрхив. ФМ-85, Д-2, ХН-2661, Х-7

⁵ МУТАрхив. ФМ-85, Д-2, ХН-416, Х-21

номын сургуулийн сургалтыг улам чанаржуулж, залуу лам нарыг элдэв төрлийн эрдэм номд төгс төгөлдөр сургах талаар ихэд анхаарч иржээ. IV, V Богдуудын лүндэн сургаальд “Жүд дацангийн хувраг болбоос Жанхар дүлцэн байгуулах, тэг татах, Тарнийн ёс тэргүүтнийг уг дацангийн дэглэм дагуу хичээн дагаж сурах хэрэгтэй. Манба дацангийн хувраг болбоос Жүши, уншлага тэргүүтнийг сайн үзэж багшийг дагаж эм найруулах, эм таних, судас барих хийгээд ер нь эмийн судрыг нарийн нягт заалгаж боловсрох хэрэгтэй. Дашчойлин, Гунгаачойлин хоёр дацангийн лам, гэвхүй, багш нар шавь, хувраг нарыг ном эрдэмд хичээн сургах хэрэгтэй. Шавь хувраг нар багшид байнга бараалхаж хичээн сурч судлан жаяг дэглэмийг сайн сахиж явах хэрэгтэй. Дэчингалбын хувраг болбоос Дүйнхор ёсны чого, цаглин, сагар, чогор тэргүүтнийг уг дэглэмийн ёсоор хий жөчүүхэн ч осолдож болохгүй дагах хэрэгтэй. Уншлага ба ян, дан тэргүүтнийг сайн сурах хэрэгтэй. Зурхай дацангийн хувраг болбоос одон зурхай, хар зурхай, шар зурхай, Бидэр гарбын дэлбо зэргийг нарийн нягт боловсортол сурах хэрэгтэй. Майдар дацангийн хувраг болбоос Майдарын ёсны төвд ян дангийн журмыг султгалгүй үзэж сурах хэрэгтэй. Бас зураг, тэг, лав, сийлбэр, ланз, соёмбо, шар, сав, манж монгол үсэг тэргүүтнийг тус тусын багшид тулган тушааж сайн сургая”⁶ хэмээжээ.

Эдгээр сургууль, дацангуудын сургалтыг чанаржуулах чангатгах талаар удаа дараагийн Богд хутагтууд, Ханбо номун хан, Эрдэнэ шанзудба нарын тушаалд тодорхой дурьджээ. 1898 онд Их хүрээний Ханбо номун ханаас Хүрээний 29 аймаг, 12 дацангийн лам, гэвхүй нарт тушаасан бичигт “Эдүгээ шалган шүүж үзвээс Ланз үсгийг сурч боловсорсон хүн 12, сурах төлөвийг олж яваа хүн 7 бөгөөд эд нар цөм сайнаар сурч боловсорвоос уг албанд дутагдаж мөхөстөхгүй мэт хойшид 7 хүнээр сургуулийг хийлгэтүгэй. Соёмбо үсэгт сурч боловсорсон хүн 2, сурах төлөвийг олж яваа хүн 10 байна. Сайн сурсан 2 хүнийг хасаад 10 хүнийг байнга сургасугай. Сав үсэгт сурч яваа 29, сурах төлөвтэй 21 байна. Хойшид байнга 21 хүнээр сургууль хийлгэ. Шар үсэг болбоос язгуураас Зурхай дацангийн хуврагууд нийтээрээ сурч боловсрох хэрэгтэй. Энэ үсгийн сургууль нэн сулхан байгаа тул сургалтыг чангатгасугай. Шар үсгийн сургууль суларсанаар Баруун зуугаас ирсэн бичгийг уншиж орчуулж чадахгүйд хүрч байна. Одоогоос эхлэн сайн сурсан ганц хуврага Агваанчойдогт шавь оруулж 4 хүнийг

⁶ МУТАрхив. ФМ-85, Д-2, ХН-216, Х-4

сайтар сургасугай. Хоръёг үсэг, бадру үсэг болбоос язгуураас Ламрин, Бадам-ёго хоёр дацангийн хуваргууд цөм сурч боловсрох хуваарьтай сургууль мөн. Байцаан үзвээс сургасан, сурсан нь сайнгүй тул сар бүр тогтмол байцаан шалгаж сургалтыг сайжруулах хэрэгтэй. Лабад сурч боловсорсон хүн 17, сурах төлөвтэй 25 байна. Сайн сурсныг хасаж байнга 25 хүнийг сургая. Зураг, урлалын сургуульд сайн сурсан 25, сурах төлөвтэй 19 байна. Хойшид 19 хүнтэй байнга сургууль хийлгэе. Сийлбэрт сурч буй 19, сурах төлөвтэй 31 байна. Сайн сурсныг хасаж орыг нөхөн авч 31 хүнийг байнга сургая. Монгол бичигт аймаг бүр 1-2 хүнийг сургаж бичээч нарыг бэлтгүүлье”⁷ гэх зэргээр дурьдсан байна.

Өндөр Богдын гэгээнтнээс хурлын дуганд хурал номын хөгжим тэргүүтнийг хэрхэн байрлуулах хэрэглэхийг нарийн зааж тогтоожээ. Бишгүүрийг баруун талд, ганданг зүүн талд, зэс бүрээ баруун талд, цагаан бүрээг зүүн талд үлээ. Цан сэлнэнгээс түрүүлж хэнгэрэг дэлдэхгүй. Лам нар цөм цэвэр хувцас өмсөх хэрэгтэй. Жанчны дотор орхимж буулгаж суудал барь. Бусад цагт хурлын дуган, олны дунд орхимжийг байнга мөрлөж яв. Дашийн үед овоодой өмсөж тариа цац. Овоодойгүй бол тариа цацаж үл болно.

Аливаа хүрээ хийдийн тэргүүн ламын тухайд Ловон, цорж, да лам, ханба гэх мэт тушаал олгож байжээ. Их хүрээг бол Манжийн хаан болон Монголын Богд хаанаас зөвшөөрөн тавигдаж байсан Хамба номун хан тэргүүлнэ. Хөдөөгийн аймаг, хошууны хүрээ хийдийн тэргүүнийг Засаг ловон, 40-100 хүртэл хуврагтай хүрээ сүмийг да лам, 500-1000 хүртэл лам хурдаг томхонд тооцогдох хийдийг цорж тушаалтан тэргүүлж байсан. Зарим хүрээ хийдийн тэргүүнд Далай лам, Банчин богд, Жибзундамба хутагтаас хамбын тушаалыг олгож байжээ. Хүрээ хийдийн тэргүүн лам нь олон лам нарын дотроос нас үе үлэмж болсон, сургууль эрдэмд сайн боловсорсон, хүмүүний хувьд бие сэтгэл нь ариуссан тодорхой нэгнийг ханбын ямба хэрэглүүлэн шашин хурлын дэг жаяг, шавь хуврагийн алив хэрэг зүйлийг эрхлүүлнэ” гэж заасан байдаг. Хүрээ хийдийн хамба буюу да лам улаан торгон бүчтэй овоодой, их гэвхүй хар хөх торгон бүчтэй овоодой, унзад цагаан торгон бүчтэй овоодой, их зурхайч улаан торгон бүчтэй овоодой, Дүйнхорын лам ногоон бүчтэй овоодой, Жүдийн лам шар

⁷ Залуучуудын үнэн сонин. №65, 1954

бүчтэй овоодой хэрэглэнэ гэх мэтээр хоорондоо ялгаатай. Жанч, түшлэг, олбог, манж барих завъяа хүртэл мөнгөн, зэс мөнгөн, зэс завъяа гэх мэтээр ялгамжтай байжээ.

Их хүрээний Цаннид дацанд 10 зиндаа анги зохион байгуулж сургаад Гаарамбад тушааж Гавжийн дамжаанд бэлтгүүлэх журам тогтоож, дамжаа барих хугацааг 3-6 өдрөөр товлож, ном хэлэлцүүлэн шүүн тогтоож байв.

Хүрээ хийд сүм дуганы ойр газарт Бомбо, сангасва, зоч нарыг бүү суулга. Хэрэв улааны салбарын сүм дуган байгуулах болбол Богд Жибзундамба хутагтын зөвшөөрснөөр аглаг зэлүүд цөөн хуврагтай байгуулах журамтай байжээ.

Номын их хүрээ 1850-иад оны дунд үеэс одоогийн байгаа газарт суурьшсан тул харъяалалын тусгай нутагтай болжээ. Үүнд: Урд тал нь Туул гол, баруун тал нь Толгойтын горхины адаг, умартад Жигжидийн ам, зүүнд Баянзүрх уул хүрч байжээ. Энэ газрын дотор арван тавны цагдаа нараар байнга эргүүл хийлгэж сул хоргодон суугаа айл өрх, хүн ардыг хөөн зайлуулж байсан. Мөн хулгай хийдэг, ойрын уулнаас зөвшөөрөлгүй мод огтлох, ан хийгсэдийг илрүүлэн баривчилж баалан шийтгэж хатуу хориглож байв. Хэтэрхий хонжвортой дамын наймаа хийх, архи дарс уух, мөрийтэй тоглох, завхай зайдан явах ийм хүмүүсийг "үл өөдлөх хүмүүс" хэмээн нэрлэж үндсэн аймаг хошуунаас түшмэлүүдийг дуудан ирүүлж нутагт нь буцаалгаж байв. Худалдааны зах зээлийг дэглэм журамтай болгох, хүнсний зүйл бараа таваарын үнийг огцом өсгөхгүй байх, нүүрсийг жижиглэн худалдах, араг савны хэмжээг жижигрүүлэх, хөдөөнөөс ирэх малын замыг тосож хямд үнээр аваад яргалж өндөр үнээр зарахыг хориглож түшмэл цагдаа нараар шалгуулж байсан. Хөдөөгийн аймаг хошуудаас Хүрээнд зөвшөөрөлгүй шургалан орж ирээд ямар нэг тодорхой ажил хийгүй хөл гар сул хаяж залхууран суугчдыг "үл өөдлөх хүмүүсийн" нэгэн адилаар үзэж хөөн гаргаж байсан. 1859 оны бүртгэлээр Их хүрээнд нэгэн ажилтай албатай 471 өрх, 1653 ам, Наймаа хотод 398 өрх, 1424 ам байжээ. Ийм тоо бүртгэлийг жил бүхэн явуулж 1890-ээд он хүртэлх хугацаанд Хүрээнд ирж сул хоргодон суугчдыг цөөн боловч өрх амаар хорогдуулж багасгаж байжээ.

Богдын их шавийн харъяат хоосон ядуу 40-50 өрхийн 100-150 амыг Богдын сангаас тэжээн тэнхрүүлж зун намрын цагт Богд уулын модонд гаргаж хортон шавьж, эрвээхэйг устгуулж байгаль орчин болон хүн амд тустай үйл бүтээлгэж байжээ. Хүрээ хийдийн газар Хятад, Монгол хүмүүс архи нэрэх, дууч эмсийн газар байгуулах, мөрийтэй наадам тоглоомын газар ажиллуулах зэргээр зөрчил гаргагчдыг байнга

шалган илрүүлэн баалж шийтгэхээс эхлээд Хүрээ хотоос зайлуулан гаргах, цөлөх хүртэл арга хэмжээг авч байжээ. Лам нарыг сур харвах, даалуу хөзөр тоглох, хороо харчуудын гэр орон, зах зээлийн газраар хэсүүчлэх, эмс охидтой хольцолдон явах, пүүс дэлгүүрийн газраар дэл сул хэсэхийг хориглож чандлан харгалзаж байжээ. Майдар эргэх, Цам бүжиглэх, Цагаан сарын 14 хоногийн ерөөлд манж чанаж буян үйлдэх хэргээр эмс охидын хамт ирэгсдийг арван тавны цагдаа, аймаг дацангийн дуганч нар гудамжны ахлагч, арван гэрийн дарга нар хамтран хянаж их чөлөөгөөр өглөө оруулан орой гаргаж хүрээний дотор хонуулдаггүй байсан.

Их хүрээ 1705-1855 оны хооронд 17-18 удаа нүүж хөрс шоороо, ус агаар бохирдсон хүний биед хортой чийг бам буй болсон гэх шалтгаан зааж Манжийн хааны зөвшөөрөлтэйгээр нүүдэл хийж буурь бууцаа сэлгэж байв. Ингэж олон удаа нүүж суухын шалтгаан нь Хятад Оросын худалдаа наймааны хүмүүс цугларах, ажилгүй сул завхай хүмүүс олшрохоос болгоомжлон Хүрээг цэвэр ариун шашин шүтлэгийн аглаг буйд орон байлгахад чиглэсэн далд бодлого зорилготой байжээ. Их хүрээний нэг удаагийн нүүдэлд 1000 гаруй тэмээ, 1000 гаруй үхэр тэрэг, 900 гаруй хүний нэг сарын хоол хүнс, унаа унаштай шавийн олон аймаг, отог багаас дайчлан гаргаж байсан баримт буй. Гандан хүрээ бол угаас нарийн чанга дэглэмтэй, хувраг шавь нар нь багшийг дагаж ном эрдэмд боловсорч шашны суртлыг дэлгэрүүлэх газар мөн хэмээн 1896 оны албан бичигт дурьдсан байдаг. Хүрээний нэг удаагийн нүүдлийн тухай, Гандан хийд байгуулагдсан тухай, 1945 оны есдүгээр сард Улаанбаатар хотын IV хороонд эсэн мэнд сууж байсан 124 настай Өлзийтогтохтой Залуучуудын үнэн сонины сурвалжлагч уулзаж сонирхолтой сурвалжлагыг нийтлүүлсэн. Тэр хүн хэлэхдээ: “Би Төр Гэрэлтийн тэргүүн онд төрсөн. Их хүрээг У булангаас нүүж одоогийн байгаа газарт бууж Гандан хүрээг анх байгуулахад буян болог хэмээн санаж 2 бүдүүн шар өргөсөн. Одоо би долоон төрийн нүүр үзэж явна”⁸ гэж ярьсан байна.

Өндөр Богдын гэгээнтэн 1651 онд Төвдийн хүрээ хийдийн жишгээр Баруун хүрээнд долоон аймаг байгуулсан. 1654 онд Их хүрээний эх үүсвэрийг Сарьдигийн хийд нэртэй цогцлон бүтээхэд энэ долоон аймгийг нүүлгэж шилжүүлсэн. Аажимдаа аймгуудыг нэмсээр 29 аймаг болж олширсон. Энэ олон аймгууд болон Дамбадаржаа, Шадивлан зэрэг ойр залгаа байгаа хурал сүмийн лам нарыг нэмж оролцуулаад 1863

⁸ Залуучуудын үнэн сонин. №65, 1954

онд тоолж бүртгэхэд 10479 лам хувраг 3220 гэрт суудаг багцаа тойм гарчээ. Үүний дотор Гандан хийдэд 2589 лам хувраг 782 гэрт, Зүүн хүрээ, Дамбадаржаа, Шадивлан зэрэг газруудад 7890 лам хувраг 2438 гэрт сууж байжээ⁹.

Их хүрээний газар бол 1850-60-аад оноос хойш Орос, хятадыг холбосон наймаа худалдааны их зам болсон. Хүрээ, Хиагтаар дамжин Орос улсад Хятадын их хэмжээний цай, бараа тээвэрлэгдэн гарч байх болжээ...

Мөн Халхын аймаг хошуудаас эргэл мөргөл хийгчид, аян жин тээгчид, элдэв албан томилолтын хүмүүс байнга ирж очдог их хөлийн газар болж хувирчээ. Ийм олон хэргээр Хүрээнд ирэгсэд нь алс холын Буриад, Тува, Алтайн Урианхай, Дөрвөд, Торгууд, олон Харуул өртөөдөөс хүртэл ирж байсан. 1858 онд Хөвсгөл нуурын Урианхайн Бүгдийн дарга Чүлтэмгомбо, 1864 онд Мянгад Өөлдийн Бүгдийн дарга Дансран Мягмар нар олон хүнийг дагалдуулан Богдод мөргөхөөр иржээ. Бас Орос, Хятадын зүгээс Англи, Япон, Европын зарим улсаас эрдэмтэн, судлаачид цөөн тоогоор ирж байсан. Гаднаас ирсэн хамгийн хүндтэй, хөлтэй зочин бол 1904 онд Хүрээнд морилсон Төвдийн XIII Далай лам Түвдэнжамц болно. Түүнийг дагалдан Хамба, хэлмэрч, засаг лам, эмч, тогооч, сойвон, донир зэрэг ойр шадар хүн 51, дагалт 68 хүн, хаалгач хүлэгч зэрэг үйлчлэх хүмүүсийг оролцуулаад нийт 163 хүн ирсэн байна. Эдний нэг хоногийн зардалд асар их зүйлийг Жибузундамба хутагтын сангаас гаргаж байв. Нэг өдрийн хүнсэнд цагаан будаа 107 жин, гурил 117 жин, шар тос 105 жин, гахайн мах 5 жин, өндөг 25 ширхэг, цай 17 ширхэг, орос лаа 210 толгой, давс 30 жин, вандуй 40 жин, үүнээс гадна үлэмж хэмжээний ногоо жимсний зүйл гаргаж байсан.

Өндөр Богд Занабазарын үндэслэн байгуулсан Номын их хүрээ нь Халхын номч мэргэд цугласан шашны охь манлай газар болж хувирсан байна. Их хүрээний лам хуврагуудын дотроос XVIII-XIX зууны үед Монгол Төвдөд гайхагдсан их эрдэмтэй лам нар төрөн гарч байсан. Үүнд: Их хүрээний ханба Агваанхайдав, Их хүрээний цорж Агваанбалдан, Сангай аймгийн Агваантүвдэннаравжамба, бичээч цорж Агваанбалдан, Шижээ гавж хэмээн алдаршсан Агваандондов, Дайчин вангийн хүрээний Дандарлхарамба зэрэг хүмүүс ном эрдмээрээ гайхагдаж байжээ.

⁹ МУТАрхив. ФМ-1, Д-1, ХН-1720, Х-51

XX зууны эхэн үед Боржигон Жамц, Өөлд Совд, Зава Дамдин, Анги Шагдар, Ихэр Самдан, Дарав Бандида хутагт Агваанчойжирдондов нар Далай ламыг дагаж ирсэн Төвдийн олон лхарамба нартай ном хэлэлцэн, гартааж байжээ. Их хүрээний Дашчоймбил, Гунгаачойнзинпил, Ядгайчойнзинлин гурван дацанд сурч гүн ухааны их номын өв санг сурч судлан эзэмшээд гавж, аграмбын дамжаа барьж өндөр гэгээн цол хэргэм авсан хүн олон байв. Их хүрээний гэвш Лувсандорж, Содномцэдэн нар 1781 онд анхны гавж, гэвш Жамц Сономдагва нар 1807 онд анхны аграмба олж дамжаа барьж байжээ.

Их хүрээ бол Монголын түүх соёлын арвин их өв сантай газар байсан. Жишээлбэл: Богд хааны дөрвөн ордон, Хүрээний аймаг дацангуудад ховор нандин бурхан шүтээн, ном судар, түүх дурсгалын зүйлүүд байснаас гадна Богдын ордны дэргэд заан, сармагчин, тогос, хун шувуу, тахиа, тагтаа олон үүлдрийн нохой, муур, жижиг биетэй шотланд адуу хүртэл байсан. Богд хааны заан нэг өдөрт 60 кг цагаан гурилаар хийсэн мантуу, 60 шанага чавга, 500жин овъёос мөн олон жин жимс, ногооны нормтой байсан. Энэ үзэсгэлэнд байсан 28 шувуу 150 жин шар будаа, 30 жин улаан буудай хэрэглэх нормтой байв¹⁰.

Номын их хүрээнд 1841-1856 он хүртэл Богд байгаагүй. Энэ хугацаанд мөргөл хийгчдийн хөл татарч, мөн лам нарын сахилга бат задгайрч, хэрэг зөрчил гарах нь ихэсчээ. Зүүн хүрээний хоёр талаар баруун, зүүн дамнуурчин гэдэг Хятадын худалдааны пүүс хэмээх хашаа байшин олширч, Эрдэнэ Шанзудбагийн яамнаас Манжийн хаанд гомдол гаргаж, Хятадын олон пүүс дэлгүүрийн хашаа байшинг буулган нүүлгэж, заримыг нутаг буцаан Майдар эргэх замыг чөлөөлүүлж байжээ. 1864, 1881, 1882, 1900, 1906, 1910 онуудад Гандан, Зүүн хүрээний лам нар Хятадын шунахай худалдаачид, Хятадын цэргийн эсрэг тэмцэл хийж орон байшинг нь эвдэх, чулуу хаях зэргээр тэмцэл хийсэн тохиолол нэг бус удаа гарчээ. Өндөр гэгээн Занабазарын сэдэж санаачилсан нэг чухал зүйл бол шарын шашны гүн ухаан Энэтхэг, төвдийн уламжлалт анагаах эрдэм, одон зурхайн судлалыг нэвтрүүлэн авчирч, монгол орны онцлог байдал, хүн ардын уламжлалт мэдлэг ухаанаар баяжуулан улам нарийсган хөгжүүлж ирснийг зориуд тэмдэглэх хэрэгтэй. Өндөр Богдын гэгээнтэн 1649-1951 онд Төвдийн оронд түр хугацаагаар очихдоо нутаг угсаа

¹⁰ МУТАрхив. ФМ-85, Д-2, ХН-994, Х-41

нэгтэй Зая Бандидахутагт Лувсанпэрэнлэйг Цаннид, Чойрын гүн ухааны ном болон орчуулгад, Эрдэнэ Бандида хутагт Лувсанданзанжалцанг анагаах ухаан, зурхай ухааныг голчлон сурахыг захиад өөрөө уран дарханы ухаанд сурч төрөл бүрийн мэргэжил дадлагатай тавь гаруй төвд ламын хамт Монгол нутагтаа буцаж ирээд сүм хийд барих, бурхан шүтээн урлах, нарийн чимхлүүр ажлыг шургуу хийж Номын их хүрээ байгуулах ажилдаа орсон байна. Өндөр Богдын гэгээнтний захиасаар Төвдөд хоцорч 22-25 жил суралцсан Заяа Бандида хутагт Лувсанпэрэнлэй, Эрдэнэ Бандида хутагт Лувсанданзанжалцан нар нутагтаа ирээд хүрээ хийд байгуулж Манба Зурхай дацангуудыг үүсгэжээ. Зая Бандида хутагт Лувсанпэрэнлэйн 15 боть зохиол Сүмбүмд хүн эмнэлэг, мал эмнэлэг, судар тарнийн ухааны олон зохиол бүтээлүүд оржээ. Энэ бүхнээс улбаалан Монголын Их хүрээ болон орон нутгийн хүрээ хийдүүдээс гарамгай эмч, оточ, мэргэн зурхайч нар олноор төрөн гарсан жишээ олон буй. XVIII зууны үед Засагт хан аймгийн Эрдэнэ дүүрэгч вангийн хошууны лам Лувсандаш анагаах ухааны их эрдэмд тооцогдож, II, III Богдын шадар эмч болж "Эрдэнэ дархан" оточ цолоор шагнагдаж байжээ¹¹. Сайн ноён хан аймгийн Далай Чойнхор вангийн хошууны Лхүнрэгдандор маарамба (1830-1920), Завханы Алдархааны Самбуугийн Адарсүрэн маарамба (1877-1937) нарын зэрэг алдартай эмч оточ нар олон гарсан. Хожмын энэ мэт эрдэмтэн, эмч, сэтгэгч нарын эрдэм ухааны их ололт нь Өндөр гэгээнтний алсын хараатай гавъяа зүтгэл, үйлс бүтээлтэй шууд холбоотой. Манжийн Энх-Амгалан хаан хүртэл Халхын Жибзундамба хутагт Өндөр Богдын гэгээнтний эрдэм мэдлэгийг бишрэн шүтэж "Надад Халхын Жибзундамба хутагт шиг эрдэмтэй лам тохиолдсонгүй" гэж үнэлэн шавь орж байжээ.

Abstract: Out of over 700 monasteries existed in Mongolia, 87 were subject to direct clerical jurisprudence of Bogd Jibtsundamba Khutukt; and among which, 6 large temple complexes were established by Zanabazar, the Undur Gegeen himself.

¹¹ Ч.Банзрагч. "Хөвсгөл аймгийн түүх" УБ., 2001, 122 тал